



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/98


Бөхт

Байгаль хамгаалах сангаас хөрөнгө зарцуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйл 59.1.13, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 9 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.1.7 дахь заалт, 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 98 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хийморь хорооллын мод усалгаанд ашиглах, ус нөөцлөх зорилгоор 10 тонны ёмкостыг иргэн О.Мөнхдагваас 5,500,000 (таван сая таван зуун мянган) төгрөгөөр шууд гэрээ байгуулан худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Дээрх зардлыг Байгаль хамгаалах сангийн 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Сайхантуяа)-д зөвшөөрсүгэй.
3. Холбогдох баримтыг бүрдүүлж, санхүүгийн гүйлгээ хийхийг нягтлан бодогч (Б.Сайхантуяа), санхүүгийн баримтыг бүрдүүлэхийг нярав (Т.Батбилэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ